



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/СН

Арвайхээр


Тендерийг хүчингүй болгож, шууд  
гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн 89 дүгээр дүгнэлтийн дагуу Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн шинэчлэл (Өвөрхангай, Арвайхээр сум) тендерийн 2 дугаар багц Ерөнхий мэс заслын багаж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт шаардлагад нийцсэн нэг ч тендер ирүүлээгүй тул тендерийг хүчингүй болгож шууд гэрээ байгуулсугай.

2. Дээрх хүчингүй болсон тендерийн техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэн үнийн харьцуулалт хийж, шууд гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100900